# I-V ангийн хэл зүй, үгсийн сангийн агуулгын залгамж холбоо

| | ХЭЛ ЗҮЙ, ҮГИЙН САН | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хэл зүй | 1.4а. Эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсгийг ялган таних | 2.4а. Хэн юу ямар хэд хэчнээн, яах, яав ясан гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, өгүүлбэр, эх зохиохдоо зөв хэрэглэх | 3.4а. Эх өгүүлбэрээс хэн?, юу?, яав?, яаж?, яагаад?, ямар учраас? гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, хэрэглэх | 4.4а. Харин, иймучраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох | 5.4а. Эх, өгүүлбэр зохиохдоо хашилт, хаалт, цэг тэмдгийг зөв хэрэглэх |
| | 1.4б Эх, өгүүлбэр дэх үгсийг хэн? юу? яав? гэсэн асуултаар ялгах | 2.4б. Асуусан, хүүрнэсэн өнгө аястай өгүүлбэр зохиохдоо асуултын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх | 3.4б. Уншсан эхээс анхааруулах өгүүлбэрийг ялган таних, бичихдээ анхаарлын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх | 4.4б. Уриалсан, зөвлөсөн өнгө аясыг илтгэх үг хэллэгийг оновчтой хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох | 5.4б. Эх, өгүүлбэрт батласан, дэмжсэн өнгө аясыг илтгэсэн үг, өгүүлбэрийг оновчтой хэрэглэх |
| Үгийн нөөц | 1.4В. Өгүүлбэрийг 1-2 асуултаар дэлгэрүүлэх | "2.4в.Эсрэг утгатай үгийг таних, өгүүлбэр зохиохдоо хэрэглэх " | 3.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох | 4.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох | 5.4в. Эх, өгүүлбэр зохиохдоо ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэх |
| | | "2.4г. Хэлц үгийн тайлбарыг уншиж ойлгох, цээжилж тогтоох" | "3.4.г. Хэлц үгийн тайлбарыг уншиж ойлгох, өгүүлбэр зохиохдоо хэрэглэх " | "4.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх" | "5.4г.Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх" |

Монгол хэл 4.4а

# Холбох үгсийг хэрэглэ

Сурагчийн нэр: ................................................ Эхэлсэн: ............. он ........ сар ........ өдөр.....цаг

“Бас, харин, цаашилбал, иим учраас, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж” холбох үгс нь өгүүлбэр, цогцолборуудыг холбоно.

“ба, бөгөөд” холбох үгээр нэг төрлийн үг, өгүүлбэрийг зэрэгцүүлэн холбодог.

**1** Эхний өгүүлбэрийг холбох үгээр холбовол аль өгүүлбэртэй утга тохирох вэ?

**1-р өгүүлбэр**

- Болор ном унших дуртай.

**Холбоос**

- Харин
- Үүнээс болж
- Цаашилбал
- Иим учраас

**2-р өгүүлбэр**

- байнга номоо уншмаар санагдавч тэр бас даалгавраа хийх хэрэгтэйг ойлгосон.
- түүнд цөөхөн ном байдаг.
- номын дэлгүүрээр байнга үйлчлүүлдэг.
- өөрөө зохиол бичихийг хүсдэг.

Иим учраас → номын дэлгүүрээр байнга үйлчлүүлдэг.

**2** Өгүүлбэрт “Харин, яагаад гэвэл, иим учраас” гэсэн холбох үгээс тохирохыг нөхөж бичээрэй.

Болор өнөөдөр хичээлээсээ хоцорсон. . ..................................... өчигдөр сэрүүлэг тавихаа мартсан байлаа.

Уянга шүлэг зохиох дуртай. ....................... яруу найргийн дугуйланд сурах болов.

Болд дугуй унах дуртай. ................................ Бат морь унах дуртай.

**3** “Иим учраас, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж” зэрэг холбох үгийг оролцуулан, зурагт тохирсон өгүүлбэрийг зохиогоорой.



Саран цэцгээ өдөр бүр усалдаг. Тийм учраас цэцэг нь гоё ургалаа.





________________________________________

________________________________________

________________________________________





________________________________________

________________________________________

________________________________________



Дуусан: .............он ........сар ........өдөр......цаг Өөрийн үнэлгээ: 1 2 3

Монгол хэл 4.4а

# Холбох үгсийг хэрэглээ

Сурагчийн нэр: ..................................................  Эхэлсэн: ............. он ........ сар ........ өдөр.....цаг

**1** “Харин, бас, ба, бөгөөд”гэсэн үгээр холбож, зурагт тохирсон өгүүлбэр зохиогоорой



Отгон нохойд яс өгсөн боловч тэр идсэнгүй. Харин тэр их цангасан бололтой ус уулаа.















**2** Өгүүлбэрийн утгыг цааш үргэлжлүүлэн, гүйцээж бичээрэй.

Эрдэм сурахад нас эртдэхгүй бөгөөд

..................................................................................................................................

Эрхийг сурахаар эрдмийг сур. Яагаад гэвэл.................................................

..................................................................................................................................

Эрдмийг хичээлээр сурдаг. Харин .................................................................

..................................................................................................................................

**4** Холбох үг ашиглан, эхийг гүйцээж бичээрэй.

Баатар хурдан уншдаг. .......................... Хонгор их удаан үсэглэж уншина. Баатар Хонгорт уншихад нь туслав. ............................тэд сайн найзууд боллоо. ................ тэдний гэр ойрхон тул хичээл номоо байнга хамт хийдэг болов. ............................. Хонгор хавар болоход сурлагадаа сайжирч, Баатараас хурдан уншдаг болсон байлаа.

Дууссан: .............он ........сар ........өдөр.....цаг  Өөрийн үнэлгээ: 1 2 3

Монгол хэл 4.4б

# Уриалсан, зөвлөсөн өнгө аясыг илтгэх үг хэллэгийг оновчтой хэрэглэе

Сурагчийн нэр: ................................................ Эхэлсэн: ............. он ........ сар ........ өдөр.....цаг

**1** Доорх өгүүлбэрийн төгсгөлийг зургийн үйл явдалтай холбон ажиглаарай.





| | | |
|---|---|---|
| Зуухны амыг хааж, гал алдахаас сэргийлье! | Хүүхдээ шүдэнзээр тоглуулахгүй байя! | Халуун тогоог газар байрлуулахаас татгалзъя! |

**2** Дээрх үйлдлүүд хүмүүст юуг уриалсан байна вэ? Зөвийг тэмдэглээрэй.

○ Анхаарал болгоомжтой байхыг
○ Гал аюултай болохыг
○ Аюулгүй байдлаа хангахыг

**3** Эцэг эхчүүдэд зориулсан зөвлөгөөг зурагтай зөв харгалзуулаарай.






- Хүүхдийн гар хүрэх газарт шүдэнз, асаагуур, хутга, заазуур, хайч зэрэг хурц ирмэгтэй зүйл байрлуулж болохгүй.

- Стандартын шаардлага хангасан цахилгааны утас, уртасгагч, залгуур зэргийг хэрэглээрэй.
- Хоолны сав, тогооны бариулыг плитка, зуухны ар тал руу харуулбал сайн.
- Халуун тогоо ашиглаж буй тохиолдолд хүүхдийн гар хүрэхгүй газарт байрлуулаарай.

- Цонх, тагт, салхивчид зориулалтын түгжээ хийвэл сайн.
- Цонх, тагтны дэргэд хүүхэд авирах боломжтой ор болон эд зүйлийг байрлуулахгүй байх нь тохиромжтой.

- Гэрийн орчинд зуух, пийшин ашигладаг бол тусгаарлалт, хамгаалалт хийгээрэй.
- Хэрэв хийн түлш, газ ашигладаг бол мэдрэгч, дохиолол ашиглах хэрэгтэй.
- Галын аюулгүй байдлыг бүрэн хангаарай.

Дууссан: .............он ........сар ........өдөр.......цаг Өөрийн үнэлгээ: 1 2 3

# Уриалсан, зөвлөсөн өнгө аясыг илтгэх үг хэллэгийг оновчтой хэрэглэе

Сурагчийн нэр: .................................................. Эхэлсэн: ............. он ........ сар ........ өдөр.....цаг

**4** Зургийн үйл явдлыг зөв дугаарлан, өгүүлбэрийн төгсгөлийг зөвлөсөн утгатай болгон өөрчлөөрэй.



1. Саванд хар шороо, элс хийж тэгшлээд,цэцгээ тарихад (бэлтгэх) ........................................
2. Үрийг элстэй хольж дээрээс нь зөөлөн дарж , далд ортол нь (хучих) ………………………………
3. Цэцгээ байнга (услах) ……………….……………
4. Цэцэг гоё ургуулахын тулд чийг дулаан, орон зайг нь тохируулж (өгөх) ...........................................................................................

**5** Зургийг ажиглан, дүү нартаа юу гэж зөвлөх вэ? Аав ээж нь чамд юу гэж зөвлөдөг байсныг санаж бичээрэй.



Хүүхдийн дархлааг дэмжих тул шинэ жимс жимсгэнэ, сүү цагаан идээ байнга хэрэглэж байгаарай.

______________________________________________



______________________________________________

______________________________________________



______________________________________________

______________________________________________

______________________________________________



______________________________________________

______________________________________________

______________________________________________

Дууссан: .............он ........сар ........өдөр.......цаг Өөрийн үнэлгээ: 4 5

# Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэе

Сурагчийн нэр: ...............................................    Эхэлсэн: ............ он ........ сар ........ өдөр.....цаг

Эсрэг ухагдахуун илэрхийлж, утгаараа харилцан эрс өөр үгийг эсрэг утгатай үг гэнэ. Жишээ нь: зэрэг- сөрөг, жижиг – том, унтах – сэрэх, халуун - хүйтэн Дуудлага, бичлэг өөр боловч утгын хувьд адил үгийг ойролцоо утгатай үг гэнэ. Жишээ нь: мэхлэх - хуурах, баяр - баясал, их - том

## Даалгавар

**1** Өгөгдсөн үгийн эсрэг үгийг **цэнхрээр**, ойролцоо үгийг **шараар** будаарай.

**ХУРДАН**

| | | |
|---|---|---|
| шаламгай | тогтуун | бушуу |
| удаан | түргэн | яаралтай |

**НЭМЭХ**

| | | |
|---|---|---|
| хасах | илүүдэх | багасах |
| ихсэх | томрох | хорогдох |

**2** Зүйр үгийг үсэг нөхөж бүтээгээд, эсрэг ойролцоо үгийг ялган бичээрэй

г _ м  _ ь  у _ д _ _

г _ м _ _ _  _ ь  х _ _ _ _ _

Эсрэг үг:..........................................  Ойролцоо үг:...............................................

**3** Ойролцоо үгсийг ангилан, эгнээ үүсгээрэй




унтах,

харах,

хэлэх,

түргэн,

Дууссан: ............он ........сар ........өдөр......цаг    Өөрийн үнэлгээ: 1 2 3

Монгол хэл | 4.4в

# Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэе

Сурагчийн нэр: ................................................ Эхэлсэн: ............ он ........ сар ........ өдөр.....цаг

**1** Эсрэг үгийг нөхөж бичээрэй.

Хүний хуучин нь
Дээлийн ..................

Хэлэхэд амархан
Хийхэд ..................

Муу явахад нөхөр олон
............... явахад садан олон

Газар хатуу
..................... хол

.............. бүхэн нөхөр биш
Уурласан бүхэн ............ биш

**2** Шүлгийг ойролцоо утгатай үгээс сонгож гүйцээгээрэй.

Эрдэм номыг .......................................... {сурахын тулд, мэдэхийн тулд }

Эрхэм дүү минь.......................................... { зүтгээрэй, хичээгээрэй }

Багын найзуудаасаа ................................ {хоцрохгүйн тулд, үлдэхгүйн тулд }

Багшаасаа сайн ...................................... { сураарай ,асуугаарай, }

**3** Өгөгдсөн үгээс сонгож, өгүүлбэр зохиогоорой.



| Охин Эмэгтэй Бүсгүй | бүтээлэг юм дэвсгэр | оёх урлах бүтээх шидэх |

..........................................................................................................



| Хүүхдүүд Багачууд Охид | торт жигнэмэг бялуу хоол унд | идэх хооллох зооглох |

..........................................................................................................



| Үхэр Үнээ Мал | тугалаа зулзагаа | тэжээх хооллох хөхүүлэх |

..........................................................................................................

Дууссан: ............он ........сар ........өдөр....цаг Өөрийн үнэлгээ: 1 2 3

Монгол хэл 4.4г

# Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэе

Сурагчийн нэр: ................................................ Эхэлсэн: ............. он ........ сар ........ өдөр.....цаг

Нэг утга санааг илэрхийлэх бөгөөд аль нэг үгийг нь сольж болдоггүй нийлмэл үгийг хэлц гэнэ. Жишээ нь: амны бэлгэтэй, магнай тэних

**1** Хэлцийг тайлбартай нь харгалзуулан ижил өнгөөр ялган будаарай.

| | |
|---|---|
| ишиг эврээ ургахаар эхийгээ мөргөх | дуугүй, хариу хэлэхгүй байх |
| хошуу нэмэхээр хуруу нэм | олон юм шалгаах, асууж хоргоох |
| хэл ам сугалчих шахам | юмыг улам лавшруулах, даамжруулах |
| бүлх залгисан юм шиг | ачийг умартан эргэж тэрслэх, хорлох |
| гал дээр тос нэмэх | ажил хийж байхад ам яриа нэмэхийн оронд гар биеэр тусал |

**2** "Амаа үдүүлсэн юм шиг дуугүй суугаад ч яах вэ, гэхдээ амаа урчих шахан бусдын өмнүүр орж элдвийг ярих нь ч бас сайн юм бишээ гэж өвөө маань сургадаг байлаа" гэсэн өгүүлбэр дэх хэлц үгүүдийг тайлбарлаарай.

..........................................................................................................................

..........................................................................................................................

**3** Ойролцоо утгатай хэлц үгийг холбоорой.

- олон таван үггүй
- ам хэлээ билүүдэх
- бүлх залгисан юм шиг
- амаа ар дээрээ гартал

- Амаа үдүүлсэн юм шиг
- Амаа урчих шахан

- хагархай хэнгэрэг шиг
- амнаас нь алт унах мэт
- ам султай
- ам хэл нь гүйцэгдэхгүй

Дууссан: .............он ........сар ........өдөр..........цаг Өөрийн үнэлгээ: 1 2 3 4

## Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэе

Сурагчийн нэр: ................................................ Эхэлсэн: ............. он ........ сар ........ өдөр......цаг

**4** Онцолсон үгийг дараах хэлцээс сонгон, өгүүлбэрийг солин найруулаарай.

Даваа хүйтнээс урьдаж байшингаа дуусгахаар борви бохисхийлгүй ажиллалаа.

Даваа хүйтнээс урьдаж байшингаа дуусгахаар .................................... ажиллалаа.

| ухаан жолоогүй | толгой өндийхгүй | ум хумгүй |
|---|---|---|

**5** Цэгийн оронд тохирох хэлцийг олж, хичээнгүй бичээрэй.

“.................................” гэж ээждээ амласан ёсоор сайн сурагч болж чадсан юм.

- ☐ Хувьтай хүн хур бороонoор
- ☐ Хөл нь дөрөөнд, гар нь ганзаганд
- ☐ Хөл нь газар хүрэхгүй
- ☐ Эзэн хичээвэл заяа хичээнэ

**6** “Эр өсөж, эсгий сунана”, “ Магнай хагарах шахам”, “Хөл газар хүрэхгүй” гэсэн хэлцүүдээс нэгийг сонгон өгүүлбэр зохиогоорой.

______________________________________________

______________________________________________

______________________________________________

______________________________________________

______________________________________________

______________________________________________

**7** Хэлцийн утгыг тунгаан цэгийн оронд тохируулан харгалзуулаарай.

| | | | |
|---|---|---|---|
| Өвчин нь намдаад ..... л болчихлоо. | ○ | ○ | дөргүй бух шиг |
| Танай хүүхдүүд .... сахилгагүй юмаа. | ○ | ○ | алгын чинээ |
| Ямар хөөрхөн ........ амьтан бэ? | ○ | ○ | өрөмний өт шиг ...... |
| .............зөрүүд өвгөн юм даа. | ○ | ○ | өргөсийг нь авсан юм шиг |

Дууссан: .............он ........сар ........өдөр....цаг Өөрийн үнэлгээ: 5 6 7